

3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:

- a. Хөх ган ХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд нийлүүлэлтийг ҮЦТТТХТ ХХК-д “Хөх ган” ХК-ийн данс нээлгэн уг данснаас андеррайтер “БиДиСЕК” ХК нь нийлүүлэлтийг 2 хувааж хийнэ.
- b. Үнэт цаас гаргагч “Хөх ган” компани, андеррайтер БиДиСЕК ХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын /firm commitment/ гэрээнд заасны дагуу анхдагч зах зээлд гаргаж байгаа 20 000 000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд “БиДиСЕК” ХК нь МХБ-ийн багцын арилжаагаар 100 төгрөгийн нэрлэсэн үнээр нийлүүлэлтийг хийж худалдан авах үүрэгтэй..
- c. Хөх ган ХК-ийн үлдэх энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа 1 дансанд дээд тал нь 20 сая төгрөгийн хувьцаа худалдан авахаар хязгаарлалтыг хийж, анхдагч зах зээлийн арилжааны цаг болох 30 минутад захиалгыг төвлөрүүлэн 10 000 000 ширхэг хувьцааг үнийн ахлах дараалалаас 100 төгрөгийн үнэ хүртэл нийлүүлэлтийг хийнэ. Анхдагч зах зээл дээр бүрэн худалдагдахгүй бол арилжааны программд шивж үлдээнэ.
- d. Үнэт цаасны арилжааны мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон хөрөнгө оруулалтын зөвлөх, Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСЕК ХК-ийн www.bdsec.mn болон МХБ-ийн www.mse.mn сайтуудаас арилжааны мэдээллийг авч болно.